



ОРЧИН ҮЕИЙН ЭРХ ЗҮЙН ХӨГЖИЛ ДЭХ ХАРЬЦУУЛСАН ЭРХ ЗҮЙН ҮҮРЭГ: ОНОЛ, АРГА ЗҮЙ

THE ROLE OF COMPARATIVE LAW IN CONTEMPORARY LEGAL DEVELOPMENT: THEORY AND METHODOLOGY

Цэнджавын Амарсанаа¹

Shihihutug University, E-mail: amarsanaar@shihihutug.edu.mn, <https://orcid.org/0009-0002-8183-3081>

ӨГҮҮЛЛИЙН ТУХАЙ

Түлхүүр үгс:

харьцуулсан эрх зүй, эрх зүйн тогтолцоо, эрх зүйн хэв шинж, эрх зүйн уялдуулах үйл явц, эрх зүйн шинэчлэл, Монгол Улс.

Нийтлэлийн түүх:

Хүлээн авсан: 2026, 03 сар
Шинэчилсэн: 2023, 03 сар
Хүлээн зөвшөөрсөн:
2023, 04 сар

Keywords:

comparative law, legal systems, legal typology, legal harmonization, legal reform, Mongolia.

Article history:

Received Dec, 2024
Revised Feb, 2025
Accepted Mar, 2025

ХУРААНГУЙ

Харьцуулсан эрх зүй нь хууль зүйн шинжлэх ухааны хүрээнд бие даасан салбар бөгөөд эрх зүйн тогтолцоог судлах, шинжлэх, харьцуулах замаар тэдгээрийн ижил төстэй болон ялгаатай шинжийг тодорхойлж, орчин үеийн дэлхийн эрх зүйн тогтолцооны хэв шинжийг нарийвчлан судалж, ойлгоход чиглэдэг.

Мөн харьцуулсан эрх зүй нь тухайн улсын эрх зүйн зарчим, институтийг гүнзгийрүүлэн судлах боломжийг бүрдүүлж, эрх зүйн тогтолцооны нөлөөлөл, нийгэмд үзүүлэх өөрчлөлтийн талаар хил дамнансан өргөн хүрээний ойлголтыг олгодог.

Гадаад улсад хэрэгжиж буй эрх зүйн шийдлүүдийг харьцуулан судалж, өөрийн үндэсний нөхцөлд нийцсэн үр дүнтэй эрх зүйн загваруудыг нутагшуулах боломжтой болдог. Энэ хүрээнд харьцуулсан эрх зүйн үүрэг нь эрх зүйн шинэчлэл хийж буй Монгол Улсын хувьд онцгой ач холбогдолтой бөгөөд үндэсний хууль тогтоомжийг боловсронгуй болгох, шинэчлэх хэрэгцээтэй нягт холбоотой байна.

Иймд эрх зүйн тогтолцоонуудыг харьцуулан шинжлэх нь үндэсний хууль тогтоомжийг сайжруулах, шинэчлэх, орчин үеийн шаардлагад нийцүүлэх, улмаар эрх зүйн тогтолцооны үр нөлөөг нэмэгдүүлэх чухал хэрэгсэл болдог.

Comparative law is a distinct discipline within the framework of legal sciences that studies, examines, and compares different legal systems in order to identify their similarities and differences, and to achieve a deeper understanding of the typology of contemporary legal systems worldwide.

In addition, comparative law enables a deeper analysis of the legal principles and institutions of different states, providing a broad transnational perspective on the impact of legal systems and their influence on society.

By comparatively studying legal solutions implemented in foreign

¹Шихихутуг их сургуулийн Нийтийн эрх зүйн тэнхимийн ахлах багш, хууль зүйн доктор (Ph.D)

countries, states are able to adapt and apply effective legal models suited to their own national context. In this regard, the role of comparative law is of particular importance for Mongolia, where ongoing legal reforms are closely linked to the need for improving and modernizing national legislation.

Therefore, the comparative analysis of legal systems serves as an essential tool for enhancing, reforming, and modernizing national legislation, as well as for increasing the overall effectiveness of the legal system in line with contemporary requirements.

Энэ өгүүлэл CC BY-NC лицензийн дагуу нээлттэй хандалтын эрхтэй.



1. Танилцуулга

Нийгмийн харилцаа нь олон янзын шинж чанартай байдаг тул эрх зүйн салбар бүр нь тухайн улсын эрх зүйн тогтолцооны хүрээнд тодорхой төрлийн нийгмийн харилцааг зохицуулдаг эрх зүйн хэм хэмжээний цогц юм. Өөрөөр хэлбэл, нэг улсын эрх зүйн тогтолцоо нь өөр өөрийн эрх зүйн хэм хэмжээгээр тодорхой салбарын нийгмийн харилцааг зохицуулдаг олон төрлийн эрх зүйн салбараас бүрддэг. Эрх зүйн салбарууд нь тухайн үндэсний эрх зүйн хүрээнд өөрт хамаарах хэм хэмжээгээр зохицуулж буй нийгмийн харилцааны хүрээгээрээ харилцан ялгардаг.

Харьцуулсан эрх зүй нь эрх зүйн бие даасан салбар биш, харин хэрэглээний шинжтэй эрх зүйн шинжлэх ухааны салбар юм. Энэхүү байр суурь нь шинжлэх ухааны үндэслэлтэй бөгөөд эрх зүйн хувьд баталгаажсан байдаг. Учир нь харьцуулсан эрх зүй нь Үндсэн хуулийн эрх зүй, захиргааны эрх зүй зэрэг бусад эрх зүйн салбаруудын адил өөртөө норматив агуулга агуулахгүй, өөрөөр хэлбэл эрх зүйн хэм хэмжээг агуулдаггүй.

Иймээс харьцуулсан эрх зүй нь нийгмийн харилцааны тодорхой нэг салбарыг зохицуулах бие даасан объектгүй юм. Харьцуулсан захиргааны эрх зүйг жишээгээр авч үзэхэд энэ нь төрийн захиргааны байгууллагын бүтэц, чиг үүрэг, эрх зүйн хяналтыг зохицуулах эрх зүйн хэм хэмжээний цогцыг илэрхийлдэггүй. Харин хоёр буюу түүнээс дээш улсын төрийн захиргааны байгууллагын зохион байгуулалт, үйл ажиллагаатай холбоотой эрх зүйн актуудыг харьцуулан судлах үйл явцыг илэрхийлдэг. Энэ харьцуулалт нь тэдгээрийн зохион байгуулалтын, бүтэц, чиг үүргийн онцлог, мөн давуу болон сул талуудыг илрүүлэх, тодорхойлох зорилготой байдаг.

Харьцуулсан эрх зүйг хамгийн ерөнхий утгаар нь “дэлхийн улс орнуудын эрх зүйн тогтолцоонуудыг харьцуулан судлах үйл явц” гэж тодорхойлж болно.² Харьцуулалт нь эрх зүйн үзэгдлийг логик аргаар шинжлэх үйл ажиллагааны хувьд өөрөө шууд тогтоосон албан ёсны эрх зүйн баримт бий болгодоггүй боловч нэг буюу хэд хэдэн эрх зүйн тогтолцоонд эрх зүйн зохицуулалт бүрэлдэхэд шууд бус байдлаар нөлөөлдөг.

Мөн эрх зүйн судалгаанд хэвтээ болон босоо харьцуулалт гэсэн хоёр хэлбэрийг ялган авч үздэг. Нэг талаас, хэвтээ харьцуулалт нь ижил чанарын түвшинд байгаа

² Konrad Zweigert, Hein Kötz, *An introduction to Comparative Law*, (Oxford University Press, 1998), 2.

(жишээлбэл, АНУ, Финланд, Франц зэрэг) улс орнуудын эрх зүйн тогтолцоонуудыг хооронд нь харьцуулахыг хэлнэ³. Өөрөөр хэлбэл, тодорхой улс орнуудын эрх зүйн тогтолцоонуудын хооронд хийгдэх харьцуулалт юм. Энэ хүрээнд Монгол Улсын эрх зүйн тогтолцоог континенталь эрх зүйн уламжлалд хамаарах улс орнуудын тогтолцоотой харьцуулан судлах нь онолын болон практикийн ач холбогдолтой юм.

Нөгөө талаас, босоо харьцуулалт нь чанарын хувьд өөр өөр түвшний эрх зүйн тогтолцоонуудын хооронд хийгддэг. Жишээлбэл, хүний эрх, эрх чөлөөг хамгаалах эрх зүйн баталгааны хэлбэрүүдийг олон улсын эрх зүй, Европын Холбооны дээд түвшний эрх зүй (supranational law), эсвэл Их Британийн үндэсний эрх зүйн тогтолцооны хүрээнд харьцуулан судлах зэрэг болно.⁴ Энэ утгаараа Монгол Улсын эрх зүйн тогтолцоог олон улсын хүний эрхийн стандарт, бүс нутгийн эрх зүйн зохицуулалттай харьцуулан шинжлэх нь үндэсний хууль тогтоомжийг боловсронгуй болгоход чухал ач холбогдолтой юм.

2. Арга зүй

Энэхүү судалгаа нь харьцуулсан эрх зүйн онол, арга зүйд тулгуурласан бөгөөд эрх зүйн тогтолцоонуудын ижил төстэй болон ялгаатай шинжийг илрүүлэх зорилгоор харьцуулсан шинжилгээний арга (comparative method)-ыг үндсэн арга зүй болгон ашигласан болно.

3. Судалгааны үр дүн

Энэхүү судалгааны үр дүнд харьцуулсан эрх зүй нь эрх зүйн тогтолцоонуудын ижил төстэй болон ялгаатай шинжийг тодорхойлох төдийгүй эрх зүйн хөгжлийн нийтлэг чиг хандлагыг илрүүлэхэд чиглэсэн судалгааны арга зүй болох нь тогтоогдлоо. Макро болон микро түвшний харьцуулалтыг хослуулан хэрэглэх нь илүү үр дүнтэй бөгөөд энэ нь эрх зүйн тогтолцооны бүтэц, онцлог, хөгжлийн логикийг цогцоор нь ойлгох боломжийг бүрдүүлдэг. Мөн харьцуулсан эрх зүй нь хууль тогтоомжийг боловсронгуй болгох, эрх зүйн шинэчлэлийг хэрэгжүүлэх, олон улсын стандарттай нийцүүлэхэд практик ач холбогдолтой бөгөөд энэ нь Монгол Улсын эрх зүйн хөгжлийн хүрээнд чухал нөлөөтэй байна

Харьцуулсан эрх зүйн эхлэлийг эртний Грекээс улбаатай гэж үздэг. Эртний Грекийн ертөнцөд олон сэтгэгч, хууль тогтоогчид гадаадын хуулийг сонирхон судалж байв. Тухайлбал, Спартын Ликург, Афины Солон нар өөрсдийн улсдаа хууль тогтоохоосоо өмнө Газар дундын тэнгисийн орнуудын нутгаар аялж, тухайн орны хуулийг илүү нарийвчлан судалсан байдаг.⁵ Платон “Хууль”⁶ бүтээлдээ Грекийн хот-улсуудын хуулийг харьцуулан авч үзсэн. Тэрээр зөвхөн тэдгээрийг дүрслэн тайлбарлаад зогсохгүй, өөрийн дэвшүүлсэн “төгс үндсэн хууль”-ийн үзэл баримтлалтай тулган

³ Jaakko Husa, *A New Introduction to Comparative Law*, (Bloomsbury Publishing, 2015), 22-23.

⁴ Maurice Adams, Dirk Heirbaut, *The Method and Culture of Comparative Law*, (Hart Publishing 2014), 59.

⁵ George Mousourakis, Matteo Nicolini, *Comparative Law and Legal Traditions*, (Springer, 2019), 71.

⁶ “Laws” by Plato, <https://classics.mit.edu/Plato/laws.1.i.html> (Сүүлд үзсэн: 2026.03.22.)

шинжилж, дүн шинжилгээ хийсэн байна. Мөн Аристотель “Улс төр”⁷ бүтээлээ туурвихаасаа өмнө 153-аас доошгүй полисын үндсэн хуулийг судалсан бөгөөд үүнээс зөвхөн Афинд холбогдох хэсэг нь л өнөө үед хадгалагдан үлджээ. Иймээс энэхүү бүтээлийг харьцуулсан эрх зүйд тулгуурласан философийн эргэцүүлэл хэмээн үзэж болно.⁸

Ромын хуульчдын дунд эрх зүйн субъективизм⁹, тодорхой хэмжээнд “хууль зүйн эгоизм”¹⁰ ажиглагддаг байв. Тэд Ромын эрх зүйтэй эн тэнцэх гадаадын ямар ч эрх зүйн тогтолцоог (Грекийн эрх зүйг хүртэл) хүлээн зөвшөөрөх хандлагагүй байсан. Энэ нь бусад ард түмний хуулийг үл ойшоосон, дорд үзсэн хандлагаар илэрч байсныг Марк Туллий Цицерон¹¹-ийн “Илтгэгчийн тухай”¹² бүтээл тод илэрхийлдэг. Тэрээр Ромын эрх зүйг Ликур¹³, Дракон¹⁴, Солон¹⁵ нарын хуультай харьцуулахдаа: “Манайхаас бусад бүх иргэний эрх зүй ямар эмх цэгцгүй, бараг инээдэмтэй гэдэг нь үнэхээр итгэмээргүй”¹⁶ хэмээн тэмдэглэсэн байна. Үүнээс үзвэл ромын хуульчид өөрсдийгөө цор ганц зөв хуультай гэж үзэх хандлагатай байжээ.

Фрэнсис Бэкон¹⁷ “Шинжлэх ухааны ач холбогдол ба дэвшлийн тухай”¹⁸ бүтээлдээ хуульч хүн өөрийн үндэсний эрх зүйтэй хэт баригдсан “хууль зүйн эгоизм, нарциссизм”-аас ангижрах ёстой бөгөөд үндэсний хууль нь үнэлгээний цорын ганц шалгуур байж болохгүй гэж онцолсон.¹⁹ Энэ үзэл санаа нь өнөөг хүртэл хүчин төгөлдөр хэвээр бөгөөд харьцуулсан эрх зүйн судалгааны онолын үндэслэл болдог. Харин

⁷ “Politics” by Aristotle, <https://classics.mit.edu/Aristotle/politics.html> (Сүүлд үзсэн: 2026.03.22.)

⁸ Jan M. Smits, *Elgar Encyclopedia of Comparative Law*, (Edward Elgar Pub, 2014), 57.

⁹ Субъективизм (subjectivism) гэдэг нь үзэл бодол, үнэлгээ, шийдвэрийг бодит (объектив) баримтаас бус, харин хувь хүний дотоод хандлага, итгэл, мэдрэмжид тулгуурлан хийх хандлага юм.

¹⁰ Хууль зүйн эгоизм (legal egoism) гэдэг нь өөрийн улсын эрх зүйн тогтолцоог хамгийн зөв, дээд, төгс гэж үзэж, бусад улсын эрх зүйг үл ойшоох эсвэл дорд үнэлэх хандлага юм.

¹¹ Marcus Tullius Cicero (МЭӨ 106-43) нь Эртний Ромын нэрт уран илтгэгч, хуульч, философич, төрийн зүтгэлтэн бөгөөд Ромын эрх зүйн сэтгэлгээ, барууны улс төр, эрх зүйн онолын хөгжилд гүнзгий нөлөө үзүүлсэн сэтгэгч юм.

¹² *De Oratore* нь МЭӨ 55 онд бичигдсэн, уран илтгэх урлаг (rhetoric)-ийн тухай сонгодог бүтээл бөгөөд Ромын нийгэм, хууль зүй, төрийн амьдралд илтгэгчийн гүйцэтгэх үүргийг гүнзгий тайлбарласан зохиол юм.

¹³ *Lucurgus* нь МЭӨ IX-VIII зууны үед Спартын хууль тогтоогч бөгөөд сахилга бат, цэргийн зохион байгуулалтад тулгуурласан эрх зүйн тогтолцоог бүрдүүлж, төрийн ашиг сонирхлыг дээдлэх зарчмыг төлөвшүүлсэн юм.

¹⁴ *Draco* нь МЭӨ VII зуунд Афинд үйл ажиллагаа явуулсан хууль тогтоогч бөгөөд анхны бичмэл хууль тогтоомжийг боловсруулж, хатуу шийтгэлд тулгуурласан эрх зүйн тогтолцоог бий болгосноор хууль нь ил тод, тогтмол хэрэгжих ёстой гэсэн зарчмыг төлөвшүүлсэн юм.

¹⁵ *Solon* нь МЭӨ 638-558 оны үед Афинд үйл ажиллагаа явуулсан хууль тогтоогч бөгөөд өрийн боолчлолыг халж, иргэдийн эрхийг өргөжүүлэн, нийгмийн давхаргын тэнцвэрийг хангах шинэчлэлүүдийг хэрэгжүүлснээр Афины ардчиллын эх суурийг тавьж, хууль нь шударга ёс, тэнцвэрт байдалд тулгуурлах ёстой гэсэн үзлийг төлөвшүүлсэн юм.

¹⁶ “*Incredible est enim quam sit omne jus civile praefer hoc nostrum, inconditum et poene ridiculum*” - Marcus Tullius Cicero.

¹⁷ Francis Bacon (1561-1626) нь Английн философич, хуульч, төрийн зүтгэлтэн бөгөөд орчин үеийн шинжлэх ухааны арга зүйн үндэслэгчдийн нэг юм.

¹⁸ Фрэнсис Бэкон “*De dignitate et augmentis scientiarum*” (1623 он) бүтээлдээ үндэсний эрх зүйд хэт баригдах явдлыг шүүмжилж, харьцуулсан хандлагын ач холбогдлыг онцолсон.

¹⁹ Roberto Scarciglia, *Methods and Legal Comparison*, (Edward Elgar Publishing, 2023), 17.

Готфрид Вильгельм Лейбниц²⁰ харьцуулсан эрх зүйг дэлхийн түгээмэл түүхийн хүрээнд авч үзэж, “эрх зүйн театр”²¹ буюу бүх ард түмэн, улс орон, цаг үеийн хуулийг харьцуулан танилцуулах цогц системийг төлөвлөж байжээ

Харьцуулсан эрх зүй нь харьцангуй шинэ эрх зүйн шинжлэх ухааны салбар юм. 1900 онд Парис хотноо Францын “Харьцуулсан хууль тогтоомжийн нийгэмлэг”²²-ээс зохион байгуулсан анхны олон улсын их хурал нь энэ салбарын онол, практикийн хөгжилд шийдвэрлэх ач холбогдолтой үйл явдал болсон.²³ Францын эрдэмтэд Эдуар Ламбер²⁴ болон Рэймон Салейль²⁵ нар харьцуулсан эрх зүйг дэлхийн хөгжингүй эрх зүйн тогтолцоонуудын “эрх зүйн шийдлүүдийн нийтлэг сан” гэж тодорхойлсон байдаг.²⁶ Эдуар Ламбер болон Рэймон Салейль нар харьцуулсан эрх зүйн үзэл санааг универсалист²⁷, космополит²⁸, интернационалист²⁹, хүмүүнлэг болон нийгмийн дэвшлийг эрхэмлэсэн үзэл баримтлалын үүднээс хөгжүүлэхийг дэмжсэн. Тэд дэлхийн улс орнуудыг өөрсдийн үндэсний эрх зүйн тогтолцооны хүрээнд эрх зүйн хэм хэмжээ, эрх зүйн институтийн ойлголтыг уялдуулах, нэгдүүлэх чиглэлээр системтэй, урт хугацааны бодлого хэрэгжүүлэхийг уриалсан. Үүний эцсийн зорилго нь ирээдүйд “хүн төрөлхтний нэгдмэл, нийтлэг эрх зүй”³⁰ бий болгох явдал байв.³¹

Дээр дурдсан үзэл санааны төлөөлөгчдийн дэвшүүлсэн дэлхийн бүх улс, ард түмэнд үйлчлэх нэгдсэн, жигд эрх зүй бий болгох зорилго нь практикт бүрэн хэрэгжих боломж хязгаарлагдмал юм. Иймээс тэдний энэхүү зорилт санаачилга нь хийсвэр³² шинжтэй бөгөөд гол төлөв онолын болон академик эрх зүйн хэлэлцүүлгийн хүрээнд авч үзэгдэх боломжтой юм.

²⁰ *Gottfried Wilhelm Leibniz (1646-1716) нь Германы философич, математикч, хуульч бөгөөд Европын сэргэн мандалтын дараах үеийн хамгийн нөлөө бүхий сэтгэгчдийн нэг юм.*

²¹ *Legal Theatrum - эрх зүйн бүх тогтолцоог нэг дор харьцуулан судлах онолын төсөөлөл (концепц) юм.*

²² *Société française de législation compare - Францын Харьцуулсан хууль тогтоомжийн нийгэмлэг нь 1869 онд харьцуулсан эрх зүйн судалгааг хөгжүүлэх зорилгоор байгуулагдсан.*

²³ *Jaakko Husa, A New Introduction to Comparative Law, (Bloomsbury Publishing, 2015), 9.*

²⁴ *Édouard Lambert (1866-1947) нь Францын нэрт хуульч, харьцуулсан эрх зүйн онолч бөгөөд орчин үеийн харьцуулсан эрх зүйн хөгжилд чухал хувь нэмэр оруулсан эрдэмтэн юм.*

²⁵ *Raymond Saleilles (1855-1912) нь Францын нэрт хуульч, харьцуулсан эрх зүйн онолч бөгөөд орчин үеийн харьцуулсан эрх зүйн онолыг хөгжүүлэхэд чухал хувь нэмэр оруулсан эрдэмтэн юм.*

²⁶ *George Mousourakis, Matteo Nicolini, Comparative Law and Legal Traditions, (Springer, 2019), 4.*

²⁷ *Universalist хандлага нь эрх зүй, үнэт зүйл, зарчмуудыг бүх улс орон, хүн төрөлхтөнд нийтлэг үйлчлэх ёстой гэж үздэг бөгөөд энэ утгаараа хүний эрхийг дэлхий нийтэд адилхан хамаарах, хууль нь зөвхөн үндэсний хүрээнд бус нийтлэг стандарттай байх шаардлагатай гэж үздэг ойлголт юм.*

²⁸ *Cosmopolitan хандлага нь хүнийг зөвхөн нэг улсын иргэн бус, “дэлхийн иргэн” гэж үзэх ойлголт бөгөөд энэ утгаараа эрх зүйг улсын хилээр хязгаарлахгүй, олон соёл, эрх зүйн тогтолцоог харилцан хүндэтгэж, уялдуулах шаардлагатай гэж үздэг.*

²⁹ *Internationalist хандлага нь улс орнуудын хоорондын хамтын ажиллагаа, харилцан уялдааг чухалчлах үзэл бөгөөд энэ утгаараа эрх зүйд олон улсын гэрээ, конвенцийн хүрээнд хууль тогтоомжийг уялдуулах шаардлагатай гэж үздэг.*

³⁰ *Universal ius commune бүх улс орон, ард түмэнд нийтлэг үйлчлэх, нэгдсэн эрх зүйн тогтолцоог бий болгох онолын үзэл баримтлал юм.*

³¹ *Jaakko Husa, A New Introduction to Comparative Law, (Bloomsbury Publishing, 2015), 20.*

³² *Utopia гэдэг нь бодит байдал дээр хэрэгжих боломжгүй, төгс төгөлдөр гэж төсөөлсөн нийгэм, санаа, тогтолцоо юм.*

XX зууны хоёрдугаар хагаст олон улсын хамтын ажиллагаа эрчимжиж, шинжлэх ухаан, технологийн хурдацтай хөгжил, улс төр, эдийн засаг, соёлын томоохон өөрчлөлтүүдтэй зэрэгцэн өрнөсөн нь харьцуулсан эрх зүйн хөгжлийг шинэ шатанд гаргасан. Үүнтэй зэрэгцэн Европын Холбооны эрх зүй болон Европын эрх зүйн дэг журам төлөвших үйл явц нь харьцуулсан эрх зүйг Европ болон АНУ-ын олон их сургуулийн сургалтын хөтөлбөрт багтаахад хүргэсэн.³³ Улс орнуудын харилцан хамаарал гүнзгийрэхийн хэрээр үндэсний эрх зүйг зөвхөн дотоод хүрээнд ойлгох боломж хязгаарлагдаж, харьцуулсан эрх зүй нь пароклиализм³⁴ болон провинциализм³⁵ зэрэг явцуу, догматик хандлага³⁶-ыг даван туулж, хууль тогтоомжийг шинэчлэх, боловсронгуй болгоход чухал үүрэг гүйцэтгэж байна.

Орчин үеийн дэлхийд аливаа эрх зүйн салбарт хууль тогтоомж батлах үйл явцыг харьцуулсан эрх зүйн дэмжлэггүйгээр төсөөлөх нь нэн бэрх болжээ. Хууль тогтоогчид эрх зүйн акт боловсруулах, батлах явцдаа харьцуулсан эрх зүйд өндөр ач холбогдол өгч, бусад улс орны шилдэг туршлага, оновчтой шийдлүүдийг харгалзан үзэх хандлага давамгайлж байна.³⁷

“Харьцуулсан эрх зүй”³⁸ гэсэн нэр томъёо нь франц хэлний *Droit comparé*, итали хэлний *Diritto comparato*, испани хэлний *Derecho comparado*, хорват хэлний *Poredbeno parvo* гэсэн нэршлүүдтэй дүйцдэг. Герман хэлэнд энэ ойлголтыг *Rechtsvergleichung* буюу “эрх зүйг харьцуулах” гэж нэрлэдэг бөгөөд “харьцуулсан эрх зүй” гэж бус, “эрх зүйн харьцуулалт” гэсэн утгаар хэрэглэгддэг нь онцлог юм.

Харин Монгол Улсад Академич С.Нарангэрэл “Эрх зүйн эх тайлбар тольд бичиг”-т *Харьцуулсан эрх зүй судлал* гэж тусгасан бөгөөд “...нэг төрлийн төрийн ба эрх зүйн институт, эрх зүйн тогтолцоо, тэдгээрийн үндсэн зарчим зэргийг харьцуулах замаар янз бүрийн улсуудын эрх зүйн бүлийг судалдаг хууль зүйн шинжлэх ухааны салбар...”³⁹ гэж тайлбарласан байна.

Харьцуулсан эрх зүйн онолд судлаачид энэхүү ойлголтыг тодорхойлох олон оролдлого хийсэн байдаг. Конрад Цвайгерт, Хайн Кётц нар харьцуулсан эрх зүйг “эрх зүйг судлах объект, харьцуулалтыг үйл явц болгон авч үздэг оюуны үйл ажиллагаа”⁴⁰ гэж тодорхойлсон. Питер де Круз “харьцуулсан эрх зүй” нь тодорхой эрх зүйн уламжлал, эрх зүйн хэм хэмжээг харьцуулсан үндсэн дээр системтэйгээр судлах үйл ажиллагааг

³³ Tan Cheng-Han, Alan Koh, Topo Santoso, Umakanth Varottil and Jiangyu Wang, *Comparative Legal Education in Mathias Siems and Po Jen Yap (eds), The Cambridge Handbook of Comparative Law, (Cambridge: Cambridge University Press, 2024), 713-720* үзнэ үү.

³⁴ *Parochialism* нь аливаа үзэгдлийг зөвхөн өөрийн орон нутгийн, үндэсний хүрээнд авч үзэж, өргөн хүрээний (олон улсын) ойлголт, туршлагыг үл тоомсорлох хандлага.

³⁵ *Provincialism* нь эрх зүйн судалгаа, хууль тогтоомжийг бүс нутгийн хязгаарлагдмал хүрээнд барьж, олон улсын хөгжлийн чиг хандлагыг үл тоомсорлох сөрөг хандлага.

³⁶ *Dogmatic approach* нь аливаа үзэл, хууль, онолыг шүүмжлэлгүйгээр, өөрчлөлтгүй үнэн гэж хүлээн авч баримтлах хандлага юм.

³⁷ Uwe Kischel, *Comparative Law, (Oxford University Press, 2019), 53.*

³⁸ *Comparative law*

³⁹ *Содовсүрэнгийн Нарангэрэл, Эрх зүйн эх тайлбар толь бичиг (хоёр дахь хэвлэл), (Улаанбаатар:Адмон, 2008 он), 488 дахь тал.*

⁴⁰ *Konrad Zweigert, Hein Kötz, An introduction to Comparative Law, (Oxford University Press), 1998, 2.*

хамарна гэж үзсэн бөгөөд харьцуулсан эрх зүй нь олон шинжлэх ухааны салбарт тулгуурладаг боловч сонголтын хувьд уян хатан эклектик⁴¹ шинжтэй гэж онцолсон. Иймд харьцуулсан эрх зүй нь эрх зүй, түүх, соёл хоорондын уялдаа холбоог хүлээн зөвшөөрч, эрх зүйн тогтолцоо бүр нь тухайн ард түмний сэтгэлгээ, олон түүхэн үйл явдлын нөлөөгөөр бүрэлдсэн онцлог шинжтэй орчны бүтээгдэхүүн гэж үздэг.⁴² Профессор Радомир Лукичийн үзэж буйгаар, харьцуулсан эрх зүй нь дор хаяж хоёр эрх зүйн тогтолцоог бүхэлд нь, эсвэл тодорхой нэг хэсгээр нь зэрэгцүүлэн⁴³ судлах үйл ажиллагаа юм.⁴⁴

Харьцуулсан эрх зүйн судалгаанд “харьцуулсан эрх зүй” гэсэн нэр томъёог хоёр утгаар хэрэглэдэг гэсэн үзэл давамгайлж байна. Нэгдүгээрт, бие даасан шинжлэх ухааны эрх зүйн салбарын хувьд, хоёрдугаарт, хууль зүйн сургуулийн сургалтын хөтөлбөрт багтдаг академик хичээлийн хувьд ойлгогддог.⁴⁵

Шинжлэх ухааны салбарын хувьд харьцуулсан эрх зүй нь тодорхой улс орнуудын хоёр буюу түүнээс дээш эрх зүйн институт, эсвэл эрх зүйн тогтолцоог судлах, шинжлэх, харьцуулах замаар тэдгээрийн ижил төстэй болон ялгаатай шинжийг илрүүлэх, тайлбарлахад чиглэдэг бөгөөд энэ нь онолын болон практик зорилгыг хамаардаг. Харьцуулсан эрх зүй нь эрх зүйн янз бүрийн салбар дахь тодорхой институтууд болон дэлхийн орчин үеийн томоохон эрх зүйн тогтолцоонуудтай холбоотой системтэй мэдлэгийн цогцыг бүрдүүлдэг.⁴⁶ Үүний дагуу харьцуулсан эрх зүй нь эрх зүйн шинжлэх ухааны салбар болон хөгжсөн бөгөөд эрх зүйн мөн чанарын хувьд салбар дундын⁴⁷, мөн туслах⁴⁸ шинжтэй юм. Өөрөөр хэлбэл, харьцуулсан үндсэн хуулийн эрх зүй, харьцуулсан захиргааны эрх зүй, харьцуулсан эрүүгийн эрх зүй, харьцуулсан иргэний эрх зүй, харьцуулсан худалдааны эрх зүй зэрэг хэрэглээний шинжтэй дэд салбаруудад хуваагддаг. Эдгээр салбарууд нь харьцуулсан эрх зүйн ололт амжилтад тулгуурлан хөгждөг тул харьцуулсан эрх зүй нь тэдгээрийн хувьд туслах үүрэгтэй гэж үздэг.⁴⁹

Харьцуулсан эрх зүй нь гадаадын эерэг эрх зүйг судлахтай холбоотой. Гадаадын эрх зүйн талаарх танин мэдэхүй нь аливаа харьцуулсан эрх зүйн судалгааны эхний шат

⁴¹ *Эклектик (Eclectic) хандлага гэдэг нь “олон төрлийн онол, үзэл баримтлал, арга зүйг нэгтгэн авч, тэдгээрийн давуу талыг ашиглан шинэ тайлбар, шийдэл боловсруулах арга” юм.*

⁴² *Peter de Cruz, Comparative Law in a Changing World, (Routledge-Cavendish, 1999), 3-6 үзнэ үү.*

⁴³ *Синхрон (synchronous) тодорхой үзэгдлийг нэг цаг хугацааны хүрээнд, тухайн үеийн байдлаар зэрэгцүүлэн судлах арга юм.*

⁴⁴ *Radomir Lukić, Metodologija prava, (Beograd, 1979), 152.*

⁴⁵ *Nora V. Demleitner, Comparative Law in Legal Education, in Mathias Reimann and Reinhard Zimmermann (eds.) The Oxford Handbook of Comparative Law (2 ed.), (Oxford University Press, 2019), 321-326 үзнэ үү.*

⁴⁶ *Uwe Kischel, Comparative Law, (Oxford University Press, 2019), 146-149 үзнэ үү.*

⁴⁷ *Салбар дундын (interdisciplinary) шинжтэй судалгаа гэж хоёр буюу түүнээс дээш шинжлэх ухааны салбарын онол, арга зүй, мэдлэгийг уялдуулан нэг судалгааны объектод хэрэглэж, цогц байдлаар судлах үйл ажиллагааг ойлгоно.*

⁴⁸ *Туслах (subsidiary) шинжтэй гэдэг нь тухайн шинжлэх ухаан өөрөө бие даасан зохицуулалтын объектууд боловч бусад шинжлэх ухааны салбарын хөгжилд дэмжлэг үзүүлж, тэдгээрийн судалгаанд ашиглагддаг шинжийг илэрхийлнэ.*

⁴⁹ *Mathias Reimann, Reinhard Zimmermann, The Oxford Handbook of Comparative Law, (Oxford University Press 2008), pp. 900-1209 үзнэ үү.*

бөгөөд харьцуулсан эрх зүйн суурь үндэс болдог.⁵⁰ Нөгөө талаас, гадаадын эрх зүйг судлах нь зөвхөн тухайн улсын хэлийг мэдэхээс гадна судлагдаж буй эрх зүйн тогтолцооны тусгай нэр томъёо, ойлголтыг эзэмшсэн байхыг шаарддаг.⁵¹ Гэвч анхаарах ёстой зүйл нь “гадаадын эрх зүйг дангаар нь судлах нь өөрөө харьцуулсан эрх зүй биш” юм. Харин тухайн судалгаанд тодорхой эрх зүйн үзэгдлийг харьцуулсан байдлаар шинжлэн тайлбарласан тохиолдолд л харьцуулсан эрх зүй бодитоор хэрэгжиж байна гэж үзнэ. Иймд туршлагаас харахад судлаач нь улс бүрийн гадаад эрх зүйн үндсэн онцлогийг тус тусад нь тодорхойлон гаргаж, улмаар тэдгээрийг шүүмжлэлт харьцуулалтын үндэс болгон ашиглах нь илүү үр дүнтэй байдаг. Үүний үндсэн дээр тухайн улсын баримтлах эрх зүйн бодлогын талаар дүгнэлт гаргах боломж бүрдэх бөгөөд үүнд өөрийн үндэсний эрх зүйн тогтолцоог дахин үнэлэх асуудал ч багтаж болно.⁵²

Орчин үеийн харьцуулсан эрх зүйг онолын хувьд хоёр өөр хандлагаар авч үзэж болно. Нэгдүгээрт, “хууль тогтоомжийн харьцуулсан эрх зүй”⁵³ бөгөөд энэ нь гадаадын эрх зүйн зохицуулалтыг судалж, үндэсний чанартай эрх зүйн актуудыг боловсронгуй болгох, мөн үндэсний эерэг эрх зүйн тодорхой салбарт хэм хэмжээний нэгтгэн системтэй⁵⁴ болгоход ашиглагддаг. Энэхүү хандлага нь Франц, Австри, улмаар Герман, Швейцарь зэрэг улсын орчин үеийн кодчилолд амжилттай хэрэглэгдэж ирсэн.⁵⁵ Хоёрдугаарт, “судалгааны харьцуулсан эрх зүй”⁵⁶ бөгөөд энэ нь дэлхийн улс орнуудын эрх зүйн тогтолцоог харьцуулан судлах замаар эрх зүйн тогтолцооны хэв шинжийн талаарх танин мэдэхүйн хүрээг тэлж, тэдгээрийн бүтэц, үйл ажиллагааны талаар илүү цогц ойлголтыг бүрдүүлэхэд чиглэдэг.⁵⁷ Түүнчлэн судалгааны харьцуулсан эрх зүй нь үндэсний эрх зүйн тогтолцоонуудыг уялдуулах⁵⁸, нэгтгэх⁵⁹ хэрэгцээтэй нягт холбоотой бөгөөд бүс нутгийн болон дэлхийн зах зээл дэх бараа, үйлчилгээний солилцоонд үүсэх

⁵⁰ Mary Ann Glendon, Paolo Carozza, Colin Picker, *Comparative Legal Traditions*, (West Academic Publishing 2008), 10-11.

⁵¹ George Mousourakis, Matteo Nicolini, *Comparative Law and Legal Traditions*, (Springer 2019), 110.

⁵² Stefan Vogenauer, *Sources of Law and Legal Method in Comparative Law*, in Mathias Reimann and Reinhard Zimmermann (eds.) *The Oxford Handbook of Comparative Law* (2 ed.), Oxford University Press, 2019, 884-886 үзнэ үү.

⁵³ *Legislative comparative law* гэдэг нь “өөр өөр улс орнуудын хууль тогтоомжийг харьцуулан судалж, тэдгээрийн зохицуулалтыг ашиглан шинэ хууль боловсруулах, одоо байгаа хуулийг сайжруулахад чиглэсэн харьцуулсан эрх зүйн хэрэглээний чиглэл” юм.

⁵⁴ Эрх зүйн кодчилал (*Codification*) гэдэг нь “тараан байрласан эрх зүйн хэм хэмжээг системтэйгээр нэгтгэн, логик дараалалд оруулж, нэг цогц хууль (кодекс) хэлбэрээр батлах үйл явц” юм.

⁵⁵ Jan M. Smits, *Comparative Law and its Influence on National Legal Systems*, in Mathias Reimann and Reinhard Zimmermann (eds.) *The Oxford Handbook of Comparative Law* (2 ed.), (Oxford University Press, 2019), 516-520 үзнэ үү.

⁵⁶ *Scholarly comparative law* гэдэг нь “эрх зүйн тогтолцоо, институт, үзэл баримтлалуудыг онолын түвшинд харьцуулан судалж, эрх зүйн хөгжлийн зүй тогтол, нийтлэг хандлага, ялгаатай онцлогийг тайлбарлахад чиглэсэн эрдэм шинжилгээний судалгааны чиглэл” юм.

⁵⁷ Konrad Zweigert, Ulrich Drobnig, *International Encyclopedia of Comparative Law*, Brill 2006, (published in 17 volume) үзнэ үү.

⁵⁸ Эрх зүйн уялдуулалт (*harmonization*) гэдэг нь “өөр өөр улс орнуудын эрх зүйн зохицуулалтыг бүрэн нэгэн ижил болгохгүйгээр, харин хооронд нь нийцтэй, зөрчилгүй болгох зорилгоор ойролцоо түвшинд хүргэх үйл явц” юм.

⁵⁹ Эрх зүйн нэгдмэл болголт (*unification*) гэдэг нь “өөр өөр улс орнуудын эрх зүйн зохицуулалтыг бүрэн нэг ижил агуулга, бүтэцтэй болгох замаар нэгэн жигд хууль тогтоомжийг бий болгох үйл явц” юм.

эрх зүйн саадыг багасгахад чиглэдэг. Энэ нь улс орнуудын олон улсын харилцааны хүрээнд хамтын ажиллагаа эрчимжих, эдийн засгийн үйл ажиллагаа өргөжих, мөн хил дамнансан худалдааны харилцааг зохицуулах эрх зүйн зохицуулалтыг хөгжүүлэх шаардлага нэмэгдэхтэй холбоотой юм.⁶⁰

XIX зуунд харьцуулсан эрх зүйн шинжлэх ухаанд хандах сонирхол нэмэгдсэн нь эрх зүйн ерөнхий үзэгдлийг харьцуулан судлахад чиглэсэн төрөл бүрийн шинжлэх ухааны хүрээлэнгүүд байгуулагдахад тусгалаа олсон. Үүнд, 1894 онд байгуулагдсан Олон улсын болон харьцуулсан эрх зүйн “Их Британийн хүрээлэн”⁶¹, 1926 онд байгуулагдсан Харьцуулсан болон олон улсын хувийн эрх зүйн “Макс Планкийн хүрээлэн”⁶², 1931 онд байгуулагдсан Парисын “Харьцуулсан эрх зүйн хүрээлэн”⁶³ зэрэг багтана. Энэ хүрээнд Холбооны Бүгд Найрамдах Югослав Ард Улсад “Харьцуулсан эрх зүйн хүрээлэн” 1955 онд Холбооны Гүйцэтгэх Зөвлөлийн тогтоолоор, тухайн үеийн ерөнхийлөгч Иосип Броз Титогийн гарын үсэгтэйгээр байгуулагдсан нь онцгойлон тэмдэглэхүйц юм. Тус хүрээлэн 1956 оны 1 дүгээр сарын 1-нээс үйл ажиллагаагаа эхлүүлсэн бөгөөд дэлхийд энэ төрлийн анхны байгууллагуудын нэг байв.⁶⁴ Үүнтэй ижил загвараар Япон Улсад 1948 онд “Харьцуулсан эрх зүйн хүрээлэн”, Швейцарь Улсад 1978 онд “Харьцуулсан эрх зүйн хүрээлэн” байгуулагдсан байна.⁶⁵

Өнөө үед харьцуулсан эрх зүй нь эрх зүйн үзэл баримтлал, онол, үндсэн хууль, хууль тогтоомжийн олон улсын солилцоог боломжтой болгож байна. Ялангуяа харьцуулсан үндсэн хуулийн эрх зүй нь улс орнуудын үндсэн хуулийг харьцуулан судлах бие даасан чиглэл бөгөөд өндөр хөгжилтэй эрх зүйн тогтолцоонуудын туршлагыг судлахад чиглэдэг. Сүүлийн жилүүдэд энэ чиглэлд хандах сонирхол нэмэгдсэн нь Зүүн Европ, Африк, Латин Америкийн орнуудад үндсэн хуулийн ардчилалд шилжих үйл явцтай уялдан шинэ үндсэн хуулиуд батлагдан хэрэгжиж байгаатай холбоотой юм.

1. ХАРЬЦУУЛСАН ЭРХ ЗҮЙН СУДЛАЛ: ОНОЛ, АРГА ЗҮЙ, ЭРХ ЗҮЙН ТОГТОЛЦООНЫ ХАРЬЦУУЛАЛТ БА ЧИГ ҮҮРЭГ

Харьцуулсан эрх зүй нь бие даасан эрх зүйн шинжлэх ухааны хувьд дор хаяж хоёр буюу түүнээс дээш улсын эрх зүйн тогтолцоог харьцуулсан өнцгөөс судлахыг өөрийн судлах зүйл болгодог. Энд онцлон тэмдэглэхэд, харьцуулсан эрх зүйн судлах зүйлд транснациональ⁶⁶ шинж давамгайлдаг. Өөрөөр хэлбэл, харьцуулсан эрх зүй нь

⁶⁰ George Mousourakis, Matteo Nicolini, *Comparative Law and Legal Traditions*, (Springer 2019), 72.

⁶¹ John W. Cairns, *Development of Comparative Law in Great Britain*, in Mathias Reimann and Reinhard Zimmermann (eds.) *The Oxford Handbook of Comparative Law* (2 ed.), (Oxford University Press, 2019), 142-143.

⁶² Ingeborg Schwenzer, *Development of Comparative Law in Germany, Switzerland, and Austria*, in Mathias Reimann and Reinhard Zimmermann (eds.) *The Oxford Handbook of Comparative Law* (2 ed.), (Oxford University Press, 2019), 69-70.

⁶³ Bénédicte Fauvarque-Cosson, *Development of Comparative Law in France*, in Mathias Reimann and Reinhard Zimmermann (eds.) *The Oxford Handbook of Comparative Law* (2 ed.), (Oxford University Press, 2019), 36

⁶⁴ <https://iup.rs/en/about/background/>, (Сүүлд үзсэн: 20.03.2026).

⁶⁵ Blerton Sinani, Sami Mehmeti, *The Importance of Comparative Law for the Development of Contemporary Law*, *Juridical Tribune - Review of Comparative and International Law* 15, no. 1 (March 2025): 6.

⁶⁶ *Transnational* нь нэг улсын хүрээнээс гарч, олон улс, байгууллага, хувь хүмүүсийн хооронд үүсэх харилцаа, үйл явцыг хамарсан ойлголт юм.

газарзүйн хил хязгаараар хязгаарлагдахгүй, дэлхий даяарх эрх зүйн тогтолцоонуудыг хамруулан судалдаг.⁶⁷

Харьцуулсан эрх зүй судлалын чиг үүргийг дараах байдлаар авч үзнэ. Үүнд:

- Танин мэдэхүйн чиг үүрэг;
- Хууль тогтоогчид дэмжлэг үзүүлэх чиг үүрэг;
- Эрх зүйн боловсролын чиг үүрэг;
- Эрх зүйн нэгдлийн чиг үүрэг гэж ангилан авч үзнэ.

Харьцуулсан эрх зүй судлалын хөгжлийн талаар Роско Паунд 1934 онд “ирээдүйн хууль зүйн профессор нь эрх зүйн асуудлыг илүү сайн ойлгож, эзэмшихийн тулд харьцуулсан эрх зүйд тулгуурлах ёстой” хэмээн онцолж байжээ.⁶⁸

Хууль зүйн харьцуулалтын арга зүйн хувьд харьцуулсан эрх зүйд хоёр үндсэн түвшний хандлага ялгагдана. Үүнд: микро-харьцуулалт болон макро-харьцуулалт юм.⁶⁹

Микро-харьцуулалт нь хоёр буюу түүнээс дээш эрх зүйн тогтолцооны хүрээнд тодорхой нарийвчилсан асуудал, тухайлбал хэм хэмжээний акт, шүүхийн практик, сэдэвчилсэн эрх зүйн асуудал, эсхүл тодорхой эрх зүйн институтийг харьцуулан судлахад чиглэдэг.⁷⁰

Харин макро-харьцуулалт нь илүү өргөн хүрээнд, өөр өөр улсын эрх зүйн тогтолцооны “ерөнхий сэтгэлгээ, хэв маяг”⁷¹-ийг харьцуулан судалдаг. Энэ хүрээнд дэлхийн эрх зүйн тогтолцоог хэд хэдэн томоохон эрх зүйн бүлд ангилах, бүлэглэх, системчлэх нь макро-харьцуулалтын гол агуулга болдог. Өөрөөр хэлбэл, макро-харьцуулалт нь тодорхой нэг асуудлыг бус, харин бүхэл бүтэн эрх зүйн тогтолцоо эсхүл эрх зүйн бүлийг бүхэлд нь авч үздэг.⁷²

Макро-харьцуулалтын тод жишээ нь иргэнлэг эрх зүйн тогтолцоо ⁷³ болон нийтлэг эрх зүйн тогтолцоо⁷⁴-ийн харьцуулалт юм. Эх газрын эрх зүйн тогтолцоо буюу иргэнлэг эрх зүй тогтолцоо нь үндсэндээ бичмэл хууль, кодчилсон эрх зүйд тулгуурладаг бөгөөд түүний уг сурвалж нь Ромын эрх зүйд оршино. Энэхүү эрх зүйн уламжлал нь өнөө үед дэлхийн хамгийн эртний бөгөөд хамгийн өргөн тархсан эрх зүйн уламжлалд тооцогдож, Европ тив, Латин Америк, мөн Африк, Азийн олон улсын эрх зүйн тогтолцоонд нөлөөлсөн байна.⁷⁵

⁶⁷ John W. Head, *Great Legal Traditions: Civil Law, Common Law, and Chinese Law in Historical and Operational Perspective*, (Durham, NC: Carolina Academic Press, 2011), 21.

⁶⁸ David S. Clark, *American Comparative Law: A History*, (Oxford University Press, 2022), 321.

⁶⁹ Uwe Kischel, *Comparative Law*, (Oxford University Press, 2019), 30-31.

⁷⁰ Geoffrey Samuel, *An Introduction to Comparative Law Theory and Method*, (Hart Publishing 2014), 50-53.

⁷¹ *Spirit and style* нь эрх зүйн тогтолцооны зөвхөн хэм хэмжээний агуулга төдийгүй түүний суурь үзэл санаа болон хэрэгжилтийн хэв маягийг хамтад нь илэрхийлдэг ойлголт юм.

⁷² Jan M. Smits, *Elgar Encyclopedia of Comparative Law*, (Edward Elgar Publishing 2014), 382-383.

⁷³ *Civil law system* нь хууль тогтоомж (*statute*), кодчиллыг эрх зүйн гол эх сурвалж болгон ашиглаж, ерөнхий, хийсвэр хэм хэмжээгээр нийгмийн харилцааг зохицуулдаг эрх зүйн тогтолцоо.

⁷⁴ *Common law system* нь шүүхийн өмнөх шийдвэрүүдийг (*judicial precedent*) эрх зүйн үндсэн эх сурвалж болгон ашиглаж, тухайн шийдвэрүүдийн үндэслэлээр шинэ хэргийг шийдвэрлэдэг эрх зүйн тогтолцоо.

⁷⁵ John Henry Merryman, Rogelio Pérez-Perdomo, *The Civil Law Tradition*, (Stanford University Press 2018), 2.

Эдгээр эрх зүйн тогтолцоонууд нь дундад зуунаас эхлэн их сургуулиудад заагдаж байсан Ромын эрх зүй, дараа нь байгалийн эрх зүйн сургууль, улмаар кодчиллын үйл явцаар гүнзгий нөлөөлөгдсөн байдаг. Үүнд:

- хийсвэр эрх зүйн ойлголтыг ашиглах;
- ерөнхий шинжтэй эрх зүйн хэм хэмжээг томъёолох;
- бичмэл эх сурвалжийн давуу байдал;
- материаллаг хэм хэмжээ болон процессын хэм хэмжээг ялган салгах явдал юм.⁷⁶

Континенталь Европын эрх зүйн тогтолцооны хуульчдын үндсэн логик арга нь силлогизм⁷⁷ буюу дедукцийн арга юм. Энэ нь ерөнхий, хийсвэр эрх зүйн хэм хэмжээг тодорхой тохиолдолд хэрэглэх замаар хувь⁷⁸ эрх зүйн хэм хэмжээг гарган авах үйл явц юм.

Энэ хүрээнд дараах латин зарчмыг онцлон тэмдэглэх нь зүйтэй. “*iudicis est ius dicere, non dare*”⁷⁹ шүүгчийн үүрэг нь хууль бүтээх бус, харин хуулийг тайлбарлан хэрэглэж, тодорхой хэрэгт хэрэгжүүлэхэд оршино.⁸⁰

Нөгөө талаас нийтлэг эрх зүйн тогтолцоо буюу англо-саксоны эрх зүйн тогтолцоо нь хааны эрх мэдэл өргөжиж, төвлөрч бэхжих үйл явц, мөн хааны шүүхүүдийн үйл ажиллагааны үр дүнд бүрэлдэн тогтсон. Эдгээр шүүхүүд нь хааны эрх мэдэлд бүрэн захирагдаж, Английн нутаг дэвсгэрт нийтлэг үйлчилдэг “нийтлэг эрх зүй”-д тулгуурлан үйл ажиллагаагаа явуулж байв.

Энэхүү эрх зүйн тогтолцоо нь Ромын эрх зүй болон Европын “*ius commune*”⁸¹-ийн нөлөөгүйгээр бие даан, аяндаа хөгжсөн онцлогтойгоороо өвөрмөц системд тооцогддог. Анх Нэгдсэн Хаант Улс⁸²-д үүсэж, улмаар Английн нөлөө, колоничлолын хүрээнд бусад улс орнуудад тархсан. Английн хуульчид энэхүү эрх зүйн тогтолцооны үндэсний өвөрмөц байдал, автохтон⁸³ шинжийг онцгойлон бахархалтайгаар тэмдэглэдэг.

Өнөөдөр дэлхийн хүн амын бараг гуравны нэг нь англо-саксоны эрх зүйн тогтолцооны суурь зарчимд тулгуурласан эрх зүйн орчинд амьдарч байна.⁸⁴ Энэхүү тогтолцоонд голлон Нэгдсэн Хаант Улс, Ирланд, АНУ, Канад, Австрали, Шинэ Зеланд зэрэг улс орнууд багтана.

⁷⁶ John W. Head, *Great Legal Traditions: Civil Law, Common Law, and Chinese Law in Historical and Operational Perspective*, (Durham, NC: Carolina Academic Press), 2011, 157.

⁷⁷ Силлогизм (*sylogism*) гэдэг нь ерөнхий нөхцөлөөс тодорхой дүгнэлт гаргах логик арга юм.

⁷⁸ *Individual* гэдэг нь ерөнхий бус, харин тодорхой нэг этгээд, тохиолдол, нөхцөлд хамаарах онцгой шинжийг илэрхийлдэг ойлголт юм.

⁷⁹ Энэхүү зарчим нь шүүгч нь хууль тогтоох биш, харин батлагдсан эрх зүйн хэм хэмжээг тайлбарлан хэрэглэх үүрэгтэй гэсэн санааг илэрхийлдэг.

⁸⁰ René David, John E. C. Brierley, *Major Legal Systems in the World Today: An Introduction to the Comparative Study of Law*, (Free Press 1978), 21-22.

⁸¹ “*Ius commune*” гэдэг нь дундад зууны Европт Ромын эрх зүй болон каноны эрх зүйд тулгуурлан үүссэн, олон улс оронд нийтлэгээр хэрэглэгдэж байсан эрх зүйн нэгдсэн уламжлалыг хэлнэ.

⁸² Нэгдсэн Хаант Улс нь Англи, Шотланд, Уэльс болон Хойд Ирланд гэсэн дөрвөн бүрэлдэхүүн улсаас бүрддэг.

⁸³ *Autochthonous* нь тухайн эрх зүйн тогтолцоо гадны шууд нөлөөгүйгээр дотоод хөгжлийн явцад бүрэлдэн бий болсон, өөрийн уугуул шинжийг хадгалсан байдлыг илэрхийлдэг.

⁸⁴ 7 John W. Head, *Great Legal Traditions: Civil Law, Common Law, and Chinese Law in Historical and Operational Perspective*, (Durham, NC: Carlona Academic Press, 2011), 370.

Англо-саксоны эрх зүй нь үндсэндээ “шүүхийн эрх зүй”⁸⁵ бөгөөд олон зууны туршид шүүхийн шийдвэрээр бүрэлдэн хөгжсөн байдаг. Үүнд:

- хийсвэр эрх зүйн ойлголтыг хязгаарлагдмал хүрээнд хэрэглэх;
- казуист⁸⁶ шинжтэй, тодорхой тохиолдолд тулгуурласан эрх зүйн зохицуулалт давамгайлах;
- материаллаг болон процессын эрх зүйн хэм хэмжээ хоорондын харилцан нягт уялдаа юм.

Өмнөх шүүхийн шийдвэрүүдийн хууль зүйн үндэслэлийг шинэ хэрэгт ашиглахыг “шүүхийн жишиг”⁸⁷ гэж нэрлэдэг. Харин ийм жишигт тулгуурлан бүрэлдсэн эрх зүйг “шүүхийн практик”⁸⁸ буюу шүүхээр бүтээсэн эрх зүй гэж тодорхойлдог. Үүний үр дүнд англо-америкийн эрх зүйн онолд “индуктив”⁸⁹-ийн хандлага зонхилдог бөгөөд эрх зүйг шүүхээс бий болгосон дүрмийн цогц гэж ойлгодог. Үүнээс гадна парламентаас баталсан хууль тогтоомж буюу “статут эрх зүй”⁹⁰ мөн оршдог бөгөөд энэ нь нийгмийн харилцааг зохицуулах зорилгоор батлагдсан эрх зүйн актуудын нийлбэр юм.

Англо-америкийн хуульчдын логик сэтгэлгээ нь рациональ-прагматик шинжтэй бөгөөд “эрх зүйн адилтгал”⁹¹-ыг өргөн хэрэглэдэг. Энэ нь өмнөх шийдвэрлэгдсэн хэрэгтэй ижил буюу төстэй нөхцөл байдалд одоогийн хэргийг уялдуулан, тухайн хэм хэмжээг хэрэглэх үйл явц юм. Энэ хүрээнд дараах англо-америкийн эрх зүйн зарчмыг онцлон тэмдэглэх нь зүйтэй: “Шүүгчид баримтын хувьд хангалттай ижил төстэй өмнөх хэргүүдийн шийдвэрийг удирдлага болгон хэрэглэдэг” шүүгчид бодит нөхцөл байдал хангалттай төстэй тохиолдолд өмнө шийдвэрлэгдсэн хэргийг дагаж мөрдөнө.

Бусад эрх зүйн шинжлэх ухааны салбаруудын нэгэн адил харьцуулсан эрх зүй нь тодорхой үүргүүдтэй бөгөөд тэдгээрийг хэд хэдэн үндсэн чиглэлд ангилан авч үзэж болно. Энэ хүрээнд дараах гол үүрэг хамаарна. Үүнд:

1. **Мэдлэгийн үүрэг.** хууль зүйн сургуулиудад харьцуулсан эрх зүйг судлахын гол зорилго нь оюутнуудад дэлхийн хэмжээний эрх зүйн соёлыг төлөвшүүлж, төрөл бүрийн эрх зүйн гэр бүлд хамаарах эрх зүйн тогтолцооны талаарх суурь онолын мэдлэгийг эзэмшүүлэхэд оршино.⁹² Эртний нэгэн зарчмын дагуу: “бүх дээд түвшний мэдлэг нь харьцуулалтад тулгуурладаг” (*comparativa est omnis investigation*) хэмээн үздэг.⁹³

⁸⁵ *Jurisprudential law* гэж шүүхийн шийдвэр, эрх зүйн онол, тайлбар дээр тулгуурлан хөгжсөн эрх зүй.

⁸⁶ *Casualist method* (casuistic method) гэдэг нь ерөнхий, хийсвэр зарчимд бус, харин тодорхой хэрэг, бодит нөхцөл байдалд тулгуурлан эрх зүйн дүгнэлт хийх арга юм.

⁸⁷ *Judicial precedent* гэж шүүхийн өмнөх шийдвэрийг дараагийн ижил төстэй хэрэгт баримтлан хэрэглэх зарчим

⁸⁸ *Case law* - шүүхийн шийдвэрүүд дээр үндэслэн бүрэлдсэн эрх зүй.

⁸⁹ *Inductive method* гэж тодорхой, тусгай тохиолдлуудад тулгуурлан ерөнхий дүрэм, зарчим, дүгнэлтийг гаргах логик-эрх зүйн арга юм.

⁹⁰ *Statutory law* гэж парламент (хууль тогтоох байгууллага)-аас баталсан хууль тогтоомжийн эрх зүй.

⁹¹ *Legal analogy* гэж төсөөтэй (адил төстэй) тохиолдолд өмнөх эрх зүйн хэм хэмжээг адилтган хэрэглэж шийдвэр гаргах арга.

⁹² *Konrad Zweigert, Hein Kötz, An introduction to Comparative Law, (Oxford University Press, 1998), 15-16.*

⁹³ *Mads Andenas, Duncan Fairgrieve, Courts and Comparative Law, (Oxford University Press 2019), 28.*

2. **Хууль тогтоогчид дэмжлэг үзүүлэх үүрэг.** Дэлхийн улс орнуудын хууль тогтоогчид олон тохиолдолд сайн хууль тогтоомжийг харьцуулсан эрх зүйн тусламжгүйгээр боловсруулж боломжгүйг хүлээн зөвшөөрсөн байдаг. Иймд тэд өөрийн улсын онцлог хэрэгцээнд нийцүүлэн бусад улсын хууль тогтоомжийн туршлагаас “эрх зүйн зээлдлэг”⁹⁴ хийдэг байна. Гэхдээ “гадаад эрх зүйн зохицуулалтыг хүлээн авах” тохиолдолд онцгой анхаарал болгоомж шаардлагатай. Учир нь Германы эрдэмтэд Конрад Цвайгерт, Хайн Кётц нарын үзэж байгаагаар “давуу” гэж тооцогдсон гадаад эрх зүйн зохицуулалтыг нэвтрүүлэх санал гарсан тохиолдолд хоёр үндсэн асуултыг зайлшгүй авч үзэх шаардлагатай. Тухайн шийдэл нэгдүгээрт өөрийн эх орондоо үр ашигтай нь батлагдсан эсэх, хоёрдугаарт уг шийдэл нь нэвтрүүлж буй улс оронд бодитойгоор үр дүнтэй хэрэгжих боломжтой эсэх асуудал юм. Нэг улсад амжилттай хэрэгжсэн эрх зүйн шийдэл нь нийгэм, эдийн засаг, соёл, шашны орчин, нөхцөл байдлын ялгаатай байдлаас шалтгаалан өөр улсад тохиромжгүй, үр ашиггүй байх тохиолдол цөөнгүй гардаг.⁹⁵ Нийгмийн тодорхой бүлгүүдийн зүгээс тухайн нийгэм, улсын нийтлэг үнэт зүйлстэй зөрчилдөх гадаад эрх зүйн шийдлийг хүлээн авах, практикт хэрэгжүүлэх явцад эсэргүүцэл, сөрөг хандлага үүсэх боломжтой. Иймээс эрх зүйн шилжүүлэн нутагшуулах⁹⁶-ын амжилт, сорилт нь тухайн нийгмийн орчны тодорхой нөхцөл байдал, онцлогтой хэр нийцэж байгаагаас шууд хамаардаг.

3. **Эрх зүйн боловсролын үүрэг.** Харьцуулсан эрх зүй нь хуульчдын академик болон мэргэжлийн хөгжлийг дэмждэг чухал үүрэгтэй. Учир нь эрх зүйн боловсрол болон эрх зүйн шинжлэх ухаанд зөвхөн үндэсний эрх зүйд төвлөрөх нь хэт хязгаарлагдмал хандлага юм. Гадаадын улсуудын эрх зүйн тогтолцоог судлах нь эрх зүйн соёл хоорондын харилцан ойлголцлыг нэмэгдүүлж, тогтвортой байдлыг хөгжүүлэх, мөн өөр өөр эрх зүйн уламжлал хоорондын харилцан уялдааг дэмжихэд чухал ач холбогдолтой. Түүнчлэн энэ нь эрх зүйн уламжлалын “олон янз байдал”⁹⁷-ыг хүлээн зөвшөөрөх, хүндэтгэх хандлагыг төлөвшүүлэхэд хувь нэмэр оруулдаг.⁹⁸ Харьцуулсан эрх зүй нь хууль зүйн оюутнуудад шинэ ойлголтын хүрээ нээж өгдөг бөгөөд тэдэнд бусад ард түмний эрх зүйн соёлыг хүндэтгэх дадлыг төлөвшүүлэх замаар өөрийн улсын эрх зүйн соёлыг илүү нарийвчлан ойлгох боломжийг бүрдүүлдэг.

4. **Нэгтгэх үүрэг.** Энэ нь эрх зүйн партикуларизм давамгайлж байсан нэг буюу хэд хэдэн улсын нутаг дэвсгэрт нэгдсэн эрх зүйн тогтолцоог бий болгохыг хэлнэ. Үнэн хэрэгтээ эрх зүйн нэгтгэл нь материаллаг болон процессын эрх зүйн ижил хэм хэмжээг нэг буюу хэд хэдэн улсын хэмжээнд хүчинтэйгээр мөрдүүлэхийг илэрхийлдэг. Харьцуулсан эрх зүй нь улс орнуудын үндэсний хууль тогтоомжийг нэгтгэх үйл явцад

⁹⁴ *Legal borrowing* гэж нэг улс өөр улсын эрх зүйн зохицуулалт, институт, зарчмыг өөрийн хууль тогтоомжид авч хэрэглэх үйл явц.

⁹⁵ John W. Head, *Great Legal Traditions: Civil Law, Common Law, and Chinese Law in Historical and Operational Perspective*, (Durham, NC: Carolina Academic Press, 2011), 23.

⁹⁶ *Legal transplantation* гэж нэг улсын эрх зүйн зохицуулалт, институт, зарчмыг нөгөө улсын эрх зүйн тогтолцоонд шилжүүлэн нэвтрүүлэх, нутагшуулах үйл явц

⁹⁷ *Pluralism* гэж олон янз байдал, олон эх сурвалж, олон үзэл хандлага зэрэгцэн орших байдал.

⁹⁸ Nora V. Demleitner, *Comparative Law in Legal Education*, in Mathias Reimann and Reinhard Zimmermann (eds.) *The Oxford Handbook of Comparative Law* (2 ed.), (Oxford University Press, 2019), 322.

тодорхой нөлөө үзүүлдэг нь эргэлзээгүй. Ялангуяа энэ нь хувийн эрх зүйн салбарт эрх зүйн нэгтгэлийн үйл явцад системтэйгээр хувь нэмэр оруулдаг боловч тодорхой хэмжээнд, хязгаарлагдмал хүрээнд хэрэгждэг.

Эрх зүйн нэгтгэл нь хоёр түвшинд хэрэгждэг. Нэгдүгээрт, үндэсний түвшинд эрх зүйн нэгтгэлийг кодчиллоор дамжуулан хэрэгжүүлдэг, хоёрдугаарт, олон улсын түвшинд эрх зүйн нэгтгэлийг олон улсын дипломат бага хурлын хүрээнд хэд хэдэн улсын хооронд байгуулсан олон улсын гэрээгээр хэрэгжүүлдэг. Үндэсний түвшний эрх зүйн нэгтгэл нь эрх зүйн хэм хэмжээг системтэйгээр нэгтгэн, уялдаа холбоотой нэг цогц эрх зүйн бичиг баримт болгон боловсруулж батлахыг илэрхийлдэг.⁹⁹ Жишээ нь: Бүгд Найрамдах Хойд Македон Улсын 2006 оны Сонгуулийн кодекс, Бүгд Найрамдах Албани Улсын 2015 оны Захиргааны журмын кодекс, 1994 оны Иргэний хууль, мөн АНУ-ын 1952 оны Нэгдсэн худалдааны кодекс (UCC) зэрэг орно. Харин олон улсын түвшний эрх зүйн нэгтгэл нь эрх зүйн хэм хэмжээг нэгдсэн бүтэцтэй эрх зүйн баримт бичигт (ихэвчлэн олон улсын гэрээ) системтэйгээр нэгтгэн боловсруулахыг хэлнэ. Үүнд 1969 оны Олон улсын гэрээний эрх зүйн тухай Венийн конвенц, 1950 оны Хүний эрхийн Европын конвенц зэрэг багтана. Ийм төрлийн эрх зүйн нэгтгэлийг тодорхой эрх зүйн зарчимд тулгуурлан олон улсын байгууллагууд санаачлан боловсруулж, олон улсын дипломат бага хурлуудаар баталж,¹⁰⁰ олон талт олон улсын гэрээгээр хэрэгжүүлдэг. Олон талт олон улсын гэрээнд агуулагдсан нэгдмэл эрх зүйн хэм хэмжээнүүд нь тухайн гэрээнд оролцогч улс бүрийн парламент соёрхон баталсны дараа “*pacta sunt servanda*”¹⁰¹ зарчмын дагуу тэдгээр улсын дотоод эрх зүйн тогтолцооны салшгүй хэсэг болдог. Өнөөдрийг хүртэл зохион байгуулагдсан олон улсын дипломат бага хурлуудаар эрх зүйн бүрэн хэмжээний нэгтгэлийг хангах боломж хараахан бүрдээгүй бөгөөд зөвхөн тодорхой эрх зүйн харилцааны хүрээнд хязгаарлагдмал, хэсэгчилсэн нэгтгэл хийгдсэн байна.

Ирээдүйг харсан өнцгөөс авч үзвэл, дэлхийн хэмжээнд эрх зүй нь ялгарал¹⁰²-аас илүүтэй ойртон нийцэх¹⁰³ хандлагатай хөгжиж байна. Энэ хүрээнд олон улсын зарим байгууллага, холбоод эрх зүйн нэгтгэлийн үйл явцад чухал дэмжлэг үзүүлдэг. Үүнд: Олон улсын эрх зүйн академи¹⁰⁴, Нэгдсэн Үндэстний Байгууллагын Олон улсын худалдааны эрх зүйн комисс¹⁰⁵, Ром дахь Хувийн эрх зүйн нэгтгэлийн олон улсын

⁹⁹ Jan M. Smits, *Comparative Law and its Influence on National Legal Systems*, in Mathias Reimann and Reinhard Zimmermann (eds.) *The Oxford Handbook of Comparative Law* (2 ed.), (Oxford University Press, 2019), 504-511 үзнэ үү.

¹⁰⁰ Vladimir Đuro Degan, *Međunarodno Pravo*, (Zagreb, 2011), 113.

¹⁰¹ Олон улсын эрх зүйд *pacta sunt servanda* буюу гэрээг чанд мөрдөх зарчим үйлчилдэг бөгөөд гэрээнд оролцогч улсууд хүлээсэн үүргээ заавал биелүүлэх үүрэгтэй.

¹⁰² *Divergence* гэдэг нь эрх зүйн тогтолцоонуудын хооронд ялгаа нэмэгдэж, тэдгээр нь бие биеэсээ улам холдон хөгжих үйл явцыг илэрхийлдэг ойлголт юм.

¹⁰³ *Convergence* гэдэг нь эрх зүйн тогтолцоонуудын ялгаа багасаж, тэдгээр нь бие биедээ ойртон нийцэж хөгжих үйл явцыг илэрхийлдэг ойлголт юм.

¹⁰⁴ Олон улсын эрх зүйн академи (*Academy of International Law*) нь 1923 онд Нидерландын Гааг хотод байгуулагдсан бөгөөд олон улсын эрх зүйн судалгаа, сургалтыг хөгжүүлэх замаар эрх зүйн тогтолцоонуудын ойртолт, уялдаа холбоог дэмжихэд чухал үүрэг гүйцэтгэдэг.

¹⁰⁵ НҮБ-ын Олон улсын худалдааны эрх зүйн комисс (*UNCITRAL*) нь 1966 онд байгуулагдсан бөгөөд олон улсын худалдааны эрх зүйн хэм хэмжээг хөгжүүлэх, уялдуулах, үе шаттайгаар нэгтгэх замаар улс орнуудын эрх зүйн тогтолцооны ойртолтыг дэмжихэд чухал үүрэг гүйцэтгэдэг.

хүрээлэн¹⁰⁶, Олон улсын хувийн эрх зүйн Гаагийн бага хурал¹⁰⁷, Дэлхийн оюуны өмчийн байгууллага¹⁰⁸ зэрэг орно. Олон улсын хувийн эрх зүйн Гаагийн бага хурлын үндсэн зорилго нь “олон улсын хувийн эрх зүйн хэм хэмжээг үе шаттайгаар нэгтгэх” явдал юм. Тус байгууллагын үйл ажиллагаа нь гишүүн улсуудын гарын үсэг зурж, соёрхон батлах олон талт олон улсын конвенцын төслүүдийг боловсруулахад чиглэгддэг. Өнөөг хүртэл тус бага хурлын хүрээнд нийт 34 конвенц батлагдсан бөгөөд үүнд, тухайлбал, 1955 оны Иргэний харьяаллын хууль ба оршин суугаа газрын хуулийн зөрчлийг шийдвэрлэх тухай конвенц, 1956 оны Гадаадын компани, холбоо, байгууллагын эрх зүйн этгээдийн эрх зүйн байдлыг хүлээн зөвшөөрөх тухай конвенц зэрэг багтана.¹⁰⁹

Нэгдсэн Үндэстний Байгууллагын Олон улсын худалдааны эрх зүйн комисс¹¹⁰ нь 1966 онд байгуулагдсан бөгөөд олон улсын худалдааны эрх зүйн хэм хэмжээг хөгжүүлэх, уялдуулах, үе шаттайгаар нэгтгэх зорилготой юм. Энэ үйл ажиллагаанд бүх улс орон, ард түмний ашиг сонирхлыг, ялангуяа хөгжиж буй улс орнуудын эрх ашигт онцгой анхаарал хандуулдаг. Тус комиссын хамгийн том амжилт нь 1980 онд Вена хотод батлагдсан Олон улсын худалдааны гэрээний тухай конвенц юм.¹¹¹

Монгол Улс нь геополитикийн хувьд хоёр том эрх зүйн уламжлал бүхий хөрш орнуудын дунд оршдог, мөн дэлхийн эрх зүйн тогтолцоонд идэвхтэй интеграцчлагдаж буй орон тул эрх зүйн тогтолцооны уялдаа, нийцлийг хангах шаардлага өндөр байдаг. Иймд харьцуулсан эрх зүй нь Монгол Улсын хувьд зөвхөн онолын ач холбогдолтой бус, харин үндэсний хууль тогтоомжийг боловсронгуй болгох, олон улсын эрх зүйн орчинд нийцүүлэх, эрх зүйн шинэчлэлийг үр дүнтэй хэрэгжүүлэхэд чиглэсэн практик ач холбогдолтой юм.

4. Дүгнэлт

Харьцуулсан эрх зүй нь эрх зүйн шинжлэх ухааны бие даасан салбар боловч уламжлалт утгаараа эрх зүйн “салбар” бус, харин судалгааны арга зүй, танин мэдэхүйн хэрэгсэл бүхий салбар дундын, туслах шинжтэй онолын чиглэл болох нь тодорхой байна. Түүний үндсэн зорилго нь хоёр буюу түүнээс дээш улсын эрх зүйн тогтолцоог харьцуулан судлах замаар тэдгээрийн ижил төстэй болон ялгаатай шинжийг илрүүлж, эрх зүйн үзэгдлийг илүү гүнзгий ойлгоход оршино.

¹⁰⁶ Хувийн эрх зүйн нэгтгэлийн олон улсын хүрээлэн (UNIDROIT) нь 1926 онд байгуулагдсан бөгөөд хувийн эрх зүйн хэм хэмжээг уялдуулах, нэгтгэх замаар улс орнуудын эрх зүйн тогтолцооны ойртолтыг дэмжихэд чухал үүрэг гүйцэтгэдэг.

¹⁰⁷ Олон улсын хувийн эрх зүйн Гаагийн бага хурал (Hague Conference on Private International Law) нь 1893 онд байгуулагдсан бөгөөд олон улсын хувийн эрх зүйн хэм хэмжээг уялдуулах, конвенц боловсруулах замаар эрх зүйн тогтолцооны ойртолтыг дэмждэг.

¹⁰⁸ Дэлхийн оюуны өмчийн байгууллага (WIPO) нь 1967 онд байгуулагдсан бөгөөд оюуны өмчийн эрхийг олон улсын түвшинд хамгаалах, уялдуулах зорилготой байгууллага юм.

¹⁰⁹ Yuko Nishitani, *Comparative Conflict of Laws in Mathias Siems and Po Jen Yap (eds), The Cambridge Handbook of Comparative Law*, (Cambridge: Cambridge University Press, 2024), 674-690 үзнэ үү.

¹¹⁰ НҮБ-ын Олон улсын худалдааны эрх зүйн комисс (UNCITRAL) нь 1966 онд байгуулагдсан бөгөөд олон улсын худалдааны эрх зүйн хэм хэмжээг уялдуулах, хөгжүүлэх зорилготой байгууллага юм.

¹¹¹ Uwe Kischel, *Comparative Law*, (Oxford University Press, 2019), 65-66.

Түүхэн хөгжлийн явцад харьцуулсан эрх зүй нь эртний Грекийн философийн эргэцүүлээс эхлэн XIX-XX зууны шинжлэх ухааны институтийн түвшинд хөгжиж, өнөөдөр дэлхийн эрх зүйн тогтолцоонуудын харилцан нөлөөлөл, уялдаа холбоог судлах чухал хэрэгсэл болон төлөвшжээ. Орчин үед харьцуулсан эрх зүй нь хууль тогтоомжийн боловсруулалт, эрх зүйн шинэчлэл, олон улсын хамтын ажиллагаанд зайлшгүй шаардлагатай арга зүй болж, үндэсний эрх зүйг зөвхөн дотоод хүрээнд ойлгох хандлагыг даван туулж байна.

Харьцуулсан эрх зүйн чиг үүргүүд болох танин мэдэхүйн, хууль тогтоогчид дэмжлэг үзүүлэх, эрх зүйн боловсролын болон эрх зүйн нэгдлийн үүргүүд нь эрх зүйн шинжлэх ухаан, практикт бодитой нөлөө үзүүлж байгааг харуулж байна. Ялангуяа эрх зүйн зээлдлэг, эрх зүйн шилжүүлэн нутагшуулах үйл явц нь тухайн улсын нийгэм, эдийн засаг, соёлын онцлог нөхцөлтэй уялдан хэрэгжих шаардлагатай бөгөөд харьцуулсан судалгаанд тулгуурласан шийдвэр гаргалт онцгой ач холбогдолтой юм.

Орчин үеийн дэлхийд эрх зүйн хөгжил нь ялгарлаас илүүтэй ойртон нийцэх чиг хандлагаар тодорхойлогдож байгаа бөгөөд энэ үйл явцад олон улсын байгууллагууд, конвенцод, загвар хуулиуд чухал үүрэг гүйцэтгэж байна. Гэвч бүрэн хэмжээний эрх зүйн нэгдэл нь практикт хязгаарлагдмал хэвээр байгаа бөгөөд ихэвчлэн тодорхой салбар, харилцааны хүрээнд хэсэгчилсэн байдлаар хэрэгжиж байна.

Монгол Улсын хувьд харьцуулсан эрх зүй нь эрх зүйн шинэчлэл, хууль тогтоомжийг боловсронгуй болгох, олон улсын эрх зүйн стандарттай нийцүүлэхэд стратегийн ач холбогдолтой. Социалист тогтолцооноос зах зээлийн эдийн засагт шилжсэн онцлог нөхцөл, мөн дэлхийн эрх зүйн орчинд идэвхтэй интеграцчлагдаж буй байдал нь харьцуулсан эрх зүйн судалгааг бодит хэрэгцээ болгон хувиргаж байна. Иймд харьцуулсан эрх зүй нь зөвхөн онолын ач холбогдолтой бус, харин Монгол Улсын эрх зүйн тогтолцооны хөгжлийг дэлхийн чиг хандлагатай уялдуулахад чиглэсэн практик ач холбогдол бүхий чухал хэрэгсэл мөн гэж дүгнэж байна.

Судалгааны үр дүнд тулгуурлан харьцуулсан эрх зүйн судалгааг хууль тогтоомж боловсруулах үйл ажиллагаанд тогтмол ашиглаж, Монгол Улсад шинэ хууль боловсруулах болон мөрдөгдөж буй хууль тогтоомжийг шинэчлэх үйл явцад гадаадын эрх зүйн шилдэг туршлагыг системтэй судалж, харьцуулсан дүн шинжилгээнд тулгуурлах шаардлагатай байна. Мөн эрх зүйн шилжүүлэн нутагшуулах үйл явцад гадаад улсын зохицуулалтыг шууд хуулбарлах бус, Монгол Улсын нийгэм, эдийн засаг, соёлын онцлогт нийцүүлэн шүүмжлэлтэйгээр нэвтрүүлэх нь зүйтэй юм. Түүнчлэн харьцуулсан эрх зүйн судалгааг төрийн бодлогын түвшинд дэмжиж, хууль тогтоох болон бодлого боловсруулах байгууллагуудын дэргэд судалгаа, шинжилгээний институцийн чадавхийг бэхжүүлэх шаардлагатай. Үүнээс гадна эрх зүйн боловсролын хүрээнд их, дээд сургуулийн сургалтын хөтөлбөрт харьцуулсан эрх зүйн агуулгыг гүнзгийрүүлэн тусгаж, оюутнуудад олон улсын эрх зүйн сэтгэлгээ, хандлагыг төлөвшүүлэх нь чухал ач холбогдолтой. Цаашид Монгол Улсын эрх зүйн тогтолцоог олон улсын гэрээ, конвенц, бүс нутгийн стандарттай уялдуулах үйл явцыг эрчимжүүлэхэд харьцуулсан эрх зүйг түлхүүр арга хэрэгсэл болгон ашиглах хэрэгцээтэй бөгөөд эцэст нь судалгаанд суурилсан хууль тогтоох соёлыг төлөвшүүлж, хууль тогтоогчид шийдвэр гаргахдаа улс төрийн бус,

шинжлэх ухааны үндэслэлтэй, харьцуулсан судалгаанд тулгуурласан арга барилыг баримтлах шаардлагатай байна.

5. Эх сурвалж

- Б.Амарсанаа, *Харьцуулсан эрх зүй судлал, хоёр дахь хэвлэл, 2014 он.*
- С.Нарангэрэл, *Эрх зүйн эх тайлбар толь бичиг, хоёр дахь хэвлэл, 2008 он.*
- Осакев К. *Харьцуулсан эрх зүй судлал: Ерөнхий ба тусгай анги, бүдүүвч, 2005 он.*
- Adams, Maurice & Dirk Heirbaut, *The Method and Culture of Comparative Law, Hart Publishing, 2014.*
- Andenas, Mads & Duncan Fairgrieve, *Courts and Comparative Law, Oxford University Press, 2019.*
- Clark, David S., *American Comparative Law: A History, Oxford University Press, 2022.*
- David, René & John E. C. Brierley, *Major Legal Systems in the World Today, Free Press, 1978.*
- Degan, Vladimir Đuro, *Međunarodno Pravo, Zagreb, 2011.*
- de Cruz, Peter, *Comparative Law in a Changing World, Routledge-Cavendish, 1999.*
- Glenn, H. Patrick, *Legal Traditions of the World, 4th ed., Oxford University Press, 2010.*
- Head, John W., *Great Legal Traditions, Carolina Academic Press, 2011.*
- Husa, Jaakko, *A New Introduction to Comparative Law, Bloomsbury Publishing, 2015.*
- Kischel, Uwe, *Comparative Law, Oxford University Press, 2019.*
- Lukić, Radomir, *Metodologija prava, Beograd, 1979.*
- Mousourakis, George & Matteo Nicolini, *Comparative Law and Legal Traditions, Springer, 2019.*
- Reimann, Mathias & Reinhard Zimmermann (eds.), *The Oxford Handbook of Comparative Law, Oxford University Press, 2008/2019.*
- Samuel, Geoffrey, *An Introduction to Comparative Law Theory and Method, Hart Publishing, 2014.*
- Scarciglia, Roberto, *Methods and Legal Comparison, Edward Elgar Publishing, 2023.*
- Smits, Jan M., *Elgar Encyclopedia of Comparative Law, Edward Elgar Publishing, 2014.*
- Zweigert, Konrad & Hein Kötz, *An Introduction to Comparative Law, Oxford University Press, 1998.*
- <https://classics.mit.edu>
- <https://iup.rs/en>
- <https://legalddata.mn/>

---oOo---